



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Иргэний хөдөлгөөний намын улсын  
бүртгэлийн мэдээлэлд оруулсан  
өөрчлөлтийг бүртгүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Н.Батзориг, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Иргэний хөдөлгөөний намын дарга болон албан ёсны хаяг өөрчлөгдсөнийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн илтгэснээр хэлэлцээд,

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэний хөдөлгөөний намын дарга гэх Ө.Баяраагаас "... Иргэний хөдөлгөөний намын дарга өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, шинээр даргаа томилсон тул намын дарга Ө.Баяраа болж өөрчлөгдсөнийг бүртгүүлэх, намын хаяг Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 12 дугаар хороолол, Токиогийн гудамж, 24Б байр үйлчилгээний хэсгийн 3 тоот, утасны дугаар 88013889, 89935577 болж өөрчлөгдсөнийг бүртгэж өгнө үү" гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр Иргэний хөдөлгөөний намын дарга өөрчлөгдсөнийг болон хаягийн мэдээлэл өөрчлөгдсөнийг бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "нам дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэх" гэж заасан, энэ тохиолдолд намын дарга өөрчлөх асуудлыг тухайн намын дүрэмд заасан журмаар, олонхийн саналаар шийдвэрлэсэн нь хуулийн дээрх заалтад нийцэж байна.

Тодруулбал, Намын үндсэн дүрмийн Гуравдугаар бүлгийн 1.5-д "Иргэний Бага Чуулганы гишүүдийн 55 дээш хувийн саналаар эсвэл намын Улс Төрийн Зөвлөлийн олонхийн саналаар ээлжит бус Иргэний Их Чуулганыг зарлан хуралдуулж болно" гэж зааснаар тус намын Улс Төрийн Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус Иргэний Их Чуулганыг зарласан буюу Улс Төрийн Зөвлөл 7 гишүүнтэй, 2 гишүүн тус намаас гарсан тул оролцоогүй, үлдэх 5 гишүүн хуралдаж, өөрт олгогдсон эрхийн хүрээнд хуралдааныг товлон зарласан байна.

Намын дүрмийн 10.4.7-д "Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас намын дарга үүрэгт ажлаасаа чөлөөлүүлэх тухай хүсэлт гаргавал Улс Төрийн Зөвлөлөөр дамжуулан Иргэний Бага Чуулганаар шийдвэрлүүлнэ" гэж заасан, ээлжит бус

Иргэний Их Чуулганд намын дарга Б.Батсайхан нь намын даргаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаснаар Иргэний Их Чуулганы 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолоор намын дарга Б.Батсайханы хүсэлтийг Үндсэн дүрэмд заасны дагуу хэлэлцэж шийдвэрлэхийг Иргэний Бага Чуулганд үүрэг болгосон байна.

Мөн Намын дүрмийн 6 дугаар зүйлд “Иргэний Бага Чуулганы бүрэн эрх” гээд, 6.4-т “Намын даргыг сонгох, чөлөөлөх” гэж зааснаар 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдөр намын Иргэний Бага Чуулган хуралдаж 119 төлөөлөгч оролцсоноос 117 гишүүний буюу 99.2 хувийн саналаар намын даргаар Ө.Баяраа сонгогдсоныг баталсан нь дүрэмдээ нийцжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Хуулийн этгээдийн хувийн хэрэгт дараах мэдээллийг агуулна” гээд, 10.1.3-т “хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг ...” гэж, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5-д “намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг” гэж тус тус зааснаар намын гүйцэтгэх удирдлагын байнга оршин суугаа хаяг, түүний өөрчлөлт нь улс төрийн намын улсын бүртгэл, хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарч байна.

Иргэний хөдөлгөөний нам нь Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Бага тойруу, Мэдээлэл технологийн үндэсний парк, 304 тоот өрөөг түрээсэлж үйл ажиллагаа явуулж байсан боловч тус намын хаяг өөрчлөгдөж, цаашид Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 12 дугаар хороолол, Токиогийн гудамж 24Б байр, үйлчилгээний хэсгийн 3 тоот өрөөнд үйл ажиллагаа явуулах болсон байх тул хаягийн өөрчлөлтийг бүртгэх үндэслэлтэй.

Намын даргаар ажиллаж байсан Б.Батсайхан нь “... Хөгжлийн шинэ шатанд гарч, шинэ хүмүүсээр хүчээ сэлбэж, шинэ бодлогоор ажиллах шаардлагатай гэж үзэж, намын даргын сонгуульт ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдөл гаргаж байна” гэж намын даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгч, энэ асуудлаар маргаагүй байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2-т тус тус заасныг баримтлан Иргэний хөдөлгөөний намын даргаар Ө.Баяраа сонгогдсоныг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5-т заасныг баримтлан Иргэний хөдөлгөөний намын хаягийг “Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 12 дугаар хороолол, Токиогийн гудамж 24Б байр, үйлчилгээний хэсгийн 3 тоот” гэж, утасны дугаарыг “88013889, 89935577” гэж тус тус намын улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулсугай.

3.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ